

6257



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

ЭМ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАРТ

2023.10.13 № А-1/3954
танай -ны № -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЭЭХХЗГ/202302002 дугаартай "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл арга хэмжээний Багц № 1: "Өндөр идэвхит шингэний хроматографийн багана" нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн "Медиконт" ХХК-тай 37,950,000.00 /Гучин долоон сая есөн зуун тавин мянга/ төгрөгөөр тендерийн хүчинтэй байх хугацаанд буюу 2023 оны 10 дугаар сарын 22 -ны өдөрт багтаан гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Үнэлгээний хорооны дүгнэлт, тайлан, холбогдох бусад материалыг хавсаргав.

Хавсралт: 29 хуудастай.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

ЗУР-т (cable)
судам шийдвэрлэх
7/16

1323212864



ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалт, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2023 оны 01/753 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1."Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

О.Мөнхсоёл

Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Ш.Ариунзаяа

Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Бүртгэлийн хэлтсийн биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Цэрмаа

"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" төрийн бус байгууллагын гишүүн

А.Дэмбэрэл

"Худалдан авах үйл ажиллагааны хөтөч" төрийн бус байгууллагын гишүүн

Нарийн бичиг:

Л.Мөнхбаяр

Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн мэргэжилтэн

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (О.Мөнхсоёл)-д даалгасугай.

3.Дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбогдох бүх баримт бичгийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 28 хоногийн дотор хадгаламжийн нэгж үүсгэн архивын ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Л.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэст даалгасугай.

ДАРГА

Ц.БАТЗУЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@sra.gov.mn
Цахим хуудас: www.sra.gov.mn

2023. 10.04 № А-1/3844
танай _____-ны № _____-т

МЕДИКОНТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИД

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Тус газраас зарласан ЭЭХХЗГ/202302002 дугаартай "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний Багц №1: "Өндөр идэвхит шингэний хроматографийн багана"-ыг 37,950,000.00 /гучин долоон сая есөн зуун тавин мянга/ төгрөгөөр тус тус нийлүүлэхээр 2023 оны 9 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн танай тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгож байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6-аас доошгүй өдрийн дараа, тендер хүчинтэй байх хугацаа буюу 2023 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн дотор гэрээний маягтад гарын үсэг зурж Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт хүргүүлнэ үү.

ДАРГА

Ц.БАТЗУЛ

1323212476

**“ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ” ТӨСӨЛ АРГА, ХЭМЖЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 09 дүгээр сарын 08

Дугаар 04

Улаанбаатар хот

Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хурал цахим хэлбэрээр буюу Microsoft “Teams” программыг ашиглан 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 09:00 цагт эхлэв.

Хуралд үнэлгээний хорооны дараах бүрэлдэхүүн оролцов. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга	О.Мөнхсоёл
Нарийн бичиг	Л.Мөнхбаяр
Гишүүд	Ш.Ариунзаяа
	А.Дэмбэрэл

нарын бүрэлдэхүүнтэйгээр 80 хувийн ирцтэй хуралдав. Г.Цэрмаа техникийн саатлын улмаас хурал дууссаны хуралд оролцож чадаагүй ба цахим хурлын өрөөнд дахин тайлбарлаж саналыг авав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний Багц 1 Өндөр идэвхит шингэний хроматографийн багана нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг дахин боловсруулах.
2. Тендер шалгаруулалтыг дахин зарлах хугацааг хэлэлцэх

О.Мөнхсоёл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. Бид 2023 оны 8 сарын 08-ны өдөр тендерийн нээлтийг хийхэд оролцогч санал ирүүлээгүй байна.

Л.Мөнхбаяр: Та бүхэнд нээлтийн тэмдэглэлийг харуулъя.

Д/Д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн үнийн хөнгөлөлт	Тендерийн баталгааны дүн (Хугацаа)
Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана				
1.	-	-	-	-

О.Мөнхсоёл: За ойлголоо танилцлаа. Багц 1-т оролцогч яагаад материал ирүүлэхгүй байгаа вэ гэдгийг үнэлгээний хороогоороо хуралдаж техникийн тодорхойлолтод өөрчлөлт орох эсэх талаар хэлэлцье. Захиалагчийн төлөөлөл Ариунзаяа гишүүн санал байна уу хэлээрэй. Миний яриаг сонсож байна уу? Миний хувьд 2 удаа амжилтгүй болсон тул дахин зарлах хугацаагаа богиносгоод үзье. Хэрэв амжилтгүй болсон тохиолдолд албан бичгээр захиалагч байгууллагад хандах саналтай байна.

Л.Мөнхбаяр: Үнэлгээний хорооны даргаа Ариунзаяа гишүүний микрофон ажиллахгүй байгаа тул хариултаа бичээд явах юм байна.

Ш.Ариунзаяа: Миний хувьд мөн адил богино хугацаагаар зарлаад үзэх саналтай байна. Техникийн тодорхойлолтод өөрчлөлт орох эсэх талаар лавлаад би хариу өгье.

О.Мөнхсоёл: За ойлголоо. Төрийн бус байгууллагын төлөөлөл Дэмбэрэл гишүүн юу гэж бодож байна. Нарийн бичиг бас саналаа хэлээрэй. Ариунзаяа гишүүн лавлаад үнэлгээний хорооны нарийн бичигрүү холбогдоод өөрчлөлт орох эсэх саналаа хэлээрэй.

А.Дэмбэрэл: Дэмжиж байна.

Л.Мөнхбаяр: Миний хувьд нэмэлт саналгүй дэмжиж байна.

О.Мөнхсоёл: Тендерийн баримт бичиг болон үнэлгээний шалгуур үзүүлэлтийг үнэлгээний хорооны гишүүдийн өмнө боловсруулсаны дагуу хэвээр үлдээж тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын долоо хоног буюу 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр байхаар тогтов. Гишүүдэд санал байхгүй бол хурлыг дуусгая. Хуралд оролцсон та бүхэнд баярлалаа.

/Цэрмээ гишүүнтэй цахимаар дахин холбогдож үнэлгээний хорооны хурлаар гаргасан саналыг тааилцуулахад нэмэлт саналгүй байгаа тухайг илэрхийлэв./

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу саналын урилгыг 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр нийтэд зарлан мэдээлж, 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 11.00 цаг хүртэл тендерийн материал хүлээн авч, 11.10 цагт тендерийг нээхээр шийдвэрлэв.

Хурал 14.20 цагт хаав.

Хурлын тэмдэглэлтэй танилцан, хүлээн зөвшөөрсөн:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:
ГИШҮҮД:

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ:

 О.МӨНХСОЁЛ
 Ш.АРИУНЗАЯА
 А.ДЭМБЭРЭЛ
 Т.ЦЭРМАА
 Л.МӨНХБАЯР

ТЕНДЕРИЙН НЭЭЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ, ҮНИЙН САНАЛУУД (Тендерийн нээлт дээр зарлагдсан дүнгээр)

Гэрээний дугаар, нэр: 1 - Өндөр идэвхэт шингээний хроматографийн багана

Тендерт оролцогчийн Тендерийн зарлагдсан үнэ

Бусад мэдээлэл

№	Нэр (1)	Дүн эсхүл хувь (2)	Үнийн хөнгөлөлт (3)	Хувилбарт тендерийн үнэ (4)	Тендерээ буцааж авсан (5)	Тендерт нэмэлт, өөрчлөлт хийсэн (6)	Тендерийн баталгаа болон бусад (7)
1	Медиконт	37,950,000	0				Байгаа

Үнэлгээний хорооны гишүүд

Албан тушаал

Нэр

Гарын үсэг

1. Үнэлгээний хорооны нарийн бичиг

Л.Мөнбаяр

2. Үнэлгээний хорооны дарга

О.Мөнхсойл

3. Үнэлгээний хорооны гишүүн

Ш.Армунзаяа

4. Хөндлөнгийн гишүүн

А.Дэмбэрэл

5. Хөндлөнгийн гишүүн

Г.Цэрмаа

ТМБ

Ш.Армунзаяа

А.Дэмбэрэл

Г.Цэрмаа

**“ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ” ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 09 дүгээр сарын 26

Дугаар 05

Улаанбаатар хот

Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний Багц № 1 Өндөр идэвхит шингэний хроматографийн багана нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хурал 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр буюу Microsoft “Teams” программыг ашиглан цахимаар эхлэв.

Хурлын ирц: Хуралд үнэлгээний хорооны дараах бүрэлдэхүүн оролцов. Үүнд:
Үнэлгээний хорооны дарга О.Мөнхсоёл
Нарийн бичиг Л.Мөнхбаяр
Гишүүд Ш.Ариунзаяа
А.Дэмбэрэл

Г.Цэрмаа үнэлгээний хорооны гишүүн хуралд оролцсонгүй. 80 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн нарийвчилсан үнэлгээг хийх
2. Хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах, үнэлгээний дүгнэлтийг гаргах

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хэлэлцэх асуудал: “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээг хийх:

СОНССОН НЬ:

Л.Мөнхбаяр: Сайн байцаана уу? “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний тендерийн нээлтийг товлосон хугацаанд буюу 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 11 цаг 10 минутад нээх үед нэг компани үнийн саналыг ирүүлсэн байна. Үүнд:

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн үнийн хөнгөлөлт	Тендерийн баталгааны дүн (Хугацаа)
Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана				
1.	Медиконт	37,950,000.00	-	192,625.00

Л.Мөнхбаяр: : “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлтийн тэмдэглэлийг танилцуулж дууслаа.

О.Мөнхсоёл: За ойлголоо. Нээлтийн тэмдэглэлтэй танилцаж дууслаа. Үнэлгээний хорооны гишүүд оролцогч компаниудтай хувийн ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхээ мэдэгдэнэ үү.

Ш.Ариунзаяа: Ашиг сонирхлын зөрчилгүй.

А.Дэмбэрэл: Ашиг сонирхлын зөрчил үүсээгүй. байна.

О.Мөнхсоёл: Ашиг сонирхлын зөрчилгүй байна.

Л.Мөнхбаяр: Миний хувьд мөн адил ашиг сонирхлын зөрчил үүсээгүй.

О.Мөнхсоёл: Үнэлгээний хорооны нарийн бичиг тендер нээсэнтэй холбогдуулан оролцогчийн лавлагаа мэдээллийг танилцуулна уу.

Л.Мөнхбаяр: За ойлголоо. Оролцогчийн мэдээллийг танилцуулъя.

“Медиконт” ХХК

“Медиконт” ХХК нь Тендер нээсэн өдрийн байдлаар Нийгмийн даатгал болон Татварын өр төлбөргүй. Шүүхийн тусгай архивын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлсэн. ТӨХ 18.2-т заасан 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй буюу 11,557,500.00 дээш байх буюу 4,1 тэрбум төгрөг байгаа нь шаардлагад нийцэж байна. ТӨХ 18.2.5-т заасны дагуу 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй бөгөөд 200,000,000.00 төгрөгийн зээлжих боломжтой талаар тодорхойлолт ирүүлсэн байна.

ТӨХ 18.6-т Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэгдсэн байвал зохих жилийн тоо 2020, 2021, 2022 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй бараа нийлүүлсэн байх шаардлагыг тавьсан бөгөөд 11,557,500 төгрөгөөс дээш ажлын туршлагатай байх ба оролцогч нь 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Үйлдвэрийн зориулалттай хроматограф болон түүний дагалдах хэрэгсэл худадлан авах Нийгмийн эрүүл мэндийн төвтэй хийсэн 949,982,000 төгрөгийн гэрээ, акт ирүүлсэн. ТШЗ 19.5-т заасан Барааны засварын хугацаа нь 12 сар байх бөгөөд албан бичгээр баталгаажуулан мэдэгдэх шаардлагатай гэсний дагуу ирүүлсэн байна. ТШЗ 20.2-т заасан Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ гэсний дагуу оролцогч маягтын дагуу ирүүлсэн байна. Барааны үнийн задаргаа тус бүрийг ирүүлсэн.

О.Мөнхсоёл: Нийт тоо ширхэгийн хэмжээг тулгаад тоо ширхэг болон барааны үнийн задаргаан дээр ижил байна уу шалгацгаая.

Л.Мөнхбаяр: За ойлголоо. Техникийн тодорхойлолттой барааны үнийн хуваарьт санал болгосонтой нийцэж байгааг тулгая. Техникийн тодорхойлолтод нийт 11 төрлийн бараа байгаа нь санал болгосон тоо хэмжээтэй ижил байна. Бараа нийлүүлэлтийн хуваарь 60 хоногт багтаан нийлүүлэхээр санал болгосон байна. Тус байгууллагын санал болгож байгаа барааны техникийн тодорхойлолтод зургийг хавсаргаж ирүүлсэн байгаа энэ зургийг

захиалагчийн төлөөлөл Ариунзаяа гишүүнээр нягтлуулах шаардлагатай байна. Та хараад саналаа хэлээрэй.

Ш.Ариунзаяа: Яг мэргэжлийн байдлаар тус бараа нь мөн эсэхийг би хэлж мэдэхгүй байна.

О.Мөнхсоёл: Эхлээд бид тус оролцогчийн үйлдвэрлэгчийн зөвшөөрөл болон чанарын сертификатыг шалгах нь зөв байх.

Ш.Ариунзаяа: Мөнхбаяраа түр техникийн тодорхойлолтын зурагтай хэсгийг харуулж байгаарай. Аан за энэ зурагт үзүүлсэн бараа нь мөн юм байна.

Л.Мөнхбаяр: Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл нь Хятад Улс, Шанхай хот байрлалтай байгууллага нь Медиконт ХХК-д доор дурдсан барааг борлуулах, түгээх үнэ тогтоох эрх олгож буй талаар орчуулгын хамт ирүүлсэн байна. Мөн ISO 9001 чанарын сертификат болон барааны тайлбар каталог байдлаар ирүүлсэн байна.

О.Мөнхсоёл: Сертификат болон үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг харлаа. Энэ удаагийн зарлал чинь хэд дахь удаагийн зарлал вэ? Тус оролцогч баталгааны 12 сар байх албан бичгийг ирүүлээгүй байна уу?

Л.Мөнхбаяр: Ирүүлсэн мэдэгдлийн 10-р заалтад тусгаж ирүүлсэн байна.

О.Мөнхсоёл: Ойлголоо бүх шаардлагаа хангаж байна. Төрийн бусын гишүүд маань юу гэж бодож байна.

А.Дэмбэрэл: Шаардлагад нийцсэн гэж үзэж байна..

Л.Мөнхбаяр: Миний хувьд санал нэг байна.

Ш.Ариунзаяа: Миний хувьд мөн адил санал нэг дэмжиж байна.

О.Мөнхсоёл: За ойлголоо. Хуралд оролцсон гишүүдийн саналаар Медиконт ХХК-ийн ирүүлсэн тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзлээ. Үнэлгээний хорооны хуралд 100 хувийн саналаар холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Хуралд оролцсон та бүхэндээ баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн саналаар "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад "Медиконт" ХХК-ийн ирүүлсэн тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг захиалагчид хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Үнэлгээний тайлан, дүгнэлтийг боловсруулан захиалагчид хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг Л.Мөнхбаярт даалгав.

Хурал 11.31 цагт хаав.

Хурлын тэмдэглэлтэй танилцан, хүлээн зөвшөөрсөн:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

О.МӨНХСОЁЛ

ГИШҮҮД:

Ш.АРИУНЗАЯА

Г.ЦЭРМАА

А.ДЭМБЭРЭЛ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН

БИЧИГ

Л.МӨНХБАЯР

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

**ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ
БАГЦ-1,**

**Тендер шалгаруулалт/
гэрээний нэр:**

Дугаар:

**“Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл, арга
хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах
ЭЭХХЗГ/202302002**

**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

**“ЭМ, БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ” НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ТАЙЛАН, ДҮГНЭЛТ
Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана
Дугаар 02**

2023 оны 09 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

1. ТАНИЛЦУУЛГА

Захиалагч буюу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас албан бичгээр техникийн тодорхойлолт болон бусад холбогдох баримт бичгийг ирүүлснийг үндэслэн Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулсан.

2. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Сангийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 144 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”-ийг ашиглан тендерийн баримт бичгийг боловсруулсан.

Тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид хууль гэх” болон Сангийн сайдын 2012 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 194 дүгээр тушаалын 03 дугаар хавсралтаар баталсан “Тендерийн үнэлгээний зааврын дагуу үнэлнэ.

3. ТЕНДЕР ЗАРЛАХ БА ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ

Тендерийн баримт бичгийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэн боловсруулан 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргаар батлуулж 2023 оны 8 дугаар сарын 08-ны өдөр нээхэд оролцогч санал ирүүлээгүй тул амжилтгүй болсон. Иймд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр дахин нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан.

Тендерийн урилгыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлд нийцүүлэн үндэсний хэмжээний өдөр тутмын “Зууны мэдээ” хэвлэлийн 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн №180 (7165) дугаарт нийтэлсэн. Тендерийн урилга болон тендерийн баримт бичгийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 тоот тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-д нийцүүлэн тус тус нийтэлсэн.

4. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГА

Тендер шалгаруулалтын нээлт хийхээс өмнө тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлт ирүүлээгүй.

5. ТЕНДЕРИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА БА ХААХ ӨДӨР

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй. Хүлээн авах эцсийн хугацаа нь 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр болно.

Тендерийн хүчинтэй хугацааг сунгаагүй.

6. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙГ ИРҮҮЛЭХ БА НЭЭХ ӨДӨР

Тендерийн урилгад заасны дагуу “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” төсөл, арга хэмжээний тендерийн нээлтийг товлосон хугацаанд буюу 2023 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 11 цаг 10 минутад нээхэд Багц-1 “Өндөр идэвхит шингэний хроматографийн багана”-д 1 компани санал ирүүлсэн бөгөөд

компанийн үнийн санал, тендерийн баталгааг дуудаж, нээлтийн тэмдэглэл хөтөлж баталгаажуулсан. Үүнд:

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн үнийн хөнгөлөлт	Тендерийн баталгааны дүн (Хугацаа)
Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана				
1.	Медиконт	37,950,000.00	-	192,625.00

Нээлтийн тэмдэглэлийг хавсаргав.

7. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тендерийг хянан үзэв.

7.1. Эрх бүхий эсэх

Хуулийн 14 дүгээр зүйл, тендерийн баримт бичиг, Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4, 16 дугаар зүйлд тус тус заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан үзэв.

7.2. Гэрээг хэрэгжүүлэх чадварыг хангасан эсэх

Хуулийн 14-16 дугаар зүйл, Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 5 дугаар зүйлд заасны дагуу гэрээ хэрэгжүүлэх чадвартай эсэхийг хянан үзэв.

7.3. Шаардлагад нийцэж буй эсэхийг магадлах

Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг болон болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4, 6, 14, 15 дугаар зүйлд тус тус заасны дагуу шаардлагад нийцсэн эсэхийг магадлан үзэв.

7.4. Тендерийн баталгаа шаардлага хангасан эсэх

Хуулийн 20 дугаар зүйл болон Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасны дагуу тендерийн баталгаа ирүүлсэн эсэхийг хянан үзэв.

7.5. Үндсэн шаардлагыг хангасан эсэх

Тендерийн үнэлгээний зааврын 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасан үндсэн шаардлагыг хангасан эсэх болон Тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 17, 30 дугаар зүйлд тус тус заасныг магадлав.

Хянан үзэх хүснэгтийг хавсаргав.

8. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ТЕНДЕР ИРҮҮЛСЭН ЭСЭХ

Дээрх шаардлагуудыг хянан үзэхэд "Медиконт" ХХК-ийн ирүүлсэн тендер нь шаардлагад нийцэж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн дагуу шаардлагад нийцсэн тендер гэж үзлээ.

9. ТЕНДЕРИЙГ НАРИЙВЧЛАН ХЯНАН ҮЗЭХ

1. Шаардлага хангасан тендер ирүүлсэн "Медиконт" ХХК-ийн тендерийн материалыг хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт заасны дагуу тус тус нарийвчлан үнэлгээг хийж хянан үзэв.

ҮНЭЛГЭЭНД ХАМРУУЛАХ ТЕНДЕРИЙН ТООГ ТОГТООХ

Тендерийн үнэлгээний зааврын 7.1-д заасны дагуу хянан үзэх үе шатнаас шаардлагад нийцсэн "Медиконт" ХХК-ийн тендерт нарийвчилсан үнэлгээг хийв.

9.1. АЛДАА ЗАЛРУУЛАХ

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 дэх заалт, Тендерийн үнэлгээний зааврын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу хянан үзэхэд арифметик алдаа илрээгүй болно.

9.2. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БУЮУ ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙГ ТООЦОХ

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.1 дэх заалт, Тендерийн үнэлгээний зааврын 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт болон тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны холбогдох заалтын дагуу тус тус хянан үзэхэд үнийн хөнгөлөлт тооцохоор санал ирүүлээгүй тул үнийн хөнгөлөлт тооцоогүй.

9.3. ДОТООДЫН ДАВУУ ЭРХ ТООЦОХ

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах хүсэлт ирүүлээгүй тул дотоодын давуу эрхийн зөрүү тооцоогүй.

10. ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалаар байгуулагдсан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, эрга хэмжээний Багц № 2: "Хангамжийн материал (шил сав)"-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийж хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасны дагуу "Медиконт" ХХК-ийн ирүүлсэн тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 47 дугаар зүйлийн 47.2.2-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид хүргүүлж байна.

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн үнийн хөнгөлөлт	Шалгарсан эсэх
Багц № 1: Хангамжийн материал (шил сав)				
1.	"Медиконт" ХХК	37,950,000.00	-	Тийм

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

ГИШҮҮД:

О.МӨНХСОЁЛ

Ш.АРИУНЗАЯА

Г.ЦЭРМАА

А.ДЭМБЭРЭЛ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН

Б.ХИМЭГ:

Л.МӨНХБАЯР

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА Ц.БАТЗУЛ ТАНАА

2023 оны 09 дүгээр сарын 26

Дугаар 02

Улаанбаатар хот

ус газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар тушаалд байгуулагдсан үнэлгээний хороо "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний Багц № 1: "Өндөр идэвхит шингэний хроматографийн багана"-ын нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн "Медиконт" ХХК 37,950,000.00 (Гучин долоон сая есөн зуун тавин мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгохыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2-д заасны дагуу захиалагчид зөвлөмж болгож байна

Тендерийн үнэлгээний тайлан, хурлын тэмдэглэл, холбогдох бусад материалыг хавсаргав.

Үнэлгээний дүгнэлтийг зөвшөөрсөн эсэх:

Үнэлгээний хорооны дарга:

О.Мөнхсоёл

Тийм/үгүй

Гийшүүд:

Ш.Ариунзаяа

Ш.Ариунзаяа

Тийм/үгүй

Г.Цэрмаа

Г.Цэрмаа

Тийм/үгүй

А.Дэмбэрэл

А.Дэмбэрэл

Тийм/үгүй

Нарийн бичиг

Л.Мөнхбаяр

Л.Мөнхбаяр

Тийм/үгүй

ЗАХИАЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛ:

БАТАЛГААЖУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ДАРГА

Ц.БАТЗУЛ

Ц.БАТЗУЛ

Огноо

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТОВЧ АГУУЛГА

1. Захиалагч		
1.1 Төр	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар	
1.2 Хэл	UBH center, Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо 14210 Улаанбаатар, Монгол улс	
2. Хэрэгслийн эх үүсвэр, батлагдсан шийдвэр	Улсын төсөв	
3. Төсөл хэрэгжих хугацаа /эх үүсвэр хүмүүстэй байх хугацаа/	2023 он	
4. Төлвийн нэр, дугаар	"Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" ЭЭХХЗГ/202302002	
5. Гэрээний дугаар		
6. Гэрээний нэр	"Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл"	
7. Гэрээний товч агуулга	"Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах"	
8. Төлбөрт өртөг	Нийт батлагдсан төсөвт өртөг: 83,000,140.00 (наян гурван сая нэг зуун дөр) төгрөг Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий 1 багцаас бүрдэнэ. Үүнд: Багц № 1: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана; Төсөвт өртөг: 38,525,000.00 /Гучин найман сая таван зуун хорин таван мянга / төгрөг;	
9. Гүйцэтгэл сонгох ажиллагааны журмыг	Нээлттэй тендер шалгаруулалт	
10. Захиалагч эсхүл эрх бүхий байгууллагаар урьдчилан хяналт шаардлагатай эсэх	Тендерийн баримт бичгийг боловсруулан захиалагчаар батлуулан тендерийг зарласан.	
11. Дотоодын давуу эрхийн зөрүүг зорьгох	Тооцно.	
12. Тогтмол үнийн гэрээ	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.	
13. Санхүүжилтийн бусад эх үүсвэр байгаа бол:	Байхгүй.	
13.1 Хамтран нийлүүлэгчийн нэр		
13.2 Хамтран нийлүүлэх хувь		

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЯВЦ

1. Тендерийг		
(а) Тендер баталсан огноо	2023 он	
(б) Тендер хамгийн сүүлд өөрчилж баталсан огноо	2023 он	
2. Урьдчилсан сонголт (шаардлагатай бол)	-	
(а) Урьдчилсан сонголтод тэнцсэн хуулийн этгээдийн тоо	-	
(б) Урьдчилсан сонголтын дүнг баталсан огноо	-	
3. Урьдлыг зарлаж мэдээлсэн		
(а) Тендер тутмын сонины нэр	Зууны мэдээ	
(б) Хэвлэгдсэн огноо	2023-09-12	
(в) Бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	www.tender.gov.mn	
(г) Олон улсын хэмжээний, эсхүл олон улсын хэл дээр хэвлэгддэг хэвлэл, мэдээллийн нэр	-	
(д) Хэвлэгдсэн огноо	-	
(е) Урьдчилсан илгээсэн этгээдийн тоо	- Үгүй	
(ё) Урьдчилсан илгээсэн огноо	- Үгүй	
Тендерийн баримт бичиг	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг	
(а) Тендер хэвлэсэн огноо	2023-09-12	
(б) Тендер баталсан огноо		
(в) Тендер оролцогчдод тараасан хугацаа	10	
4. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан бол	Үгүй	
(а) Тендер огноо (бүгдийг жагсаана уу)	-	
(б) Тендер баталсан огноо	-	
3.1 Тендер шалгаруулалтын өмнөх уулзалт хийсэн бол, огноо	Үгүй	
4.1 Тендер шалгаруулалтын өмнөх уулзалтын хийсэн бол тэмдэглэлийг тендер оролцогчдод тараасан огноо	Үгүй	

ТЕНДЕРИЙГ ХҮЛЭЭН АВАХ БОЛОН НЭЭХ

1. Тендер хүлээн авах эцсийн хугацаа		
(а) анхны огноо, цаг	2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 11 цаг 00 минут	
(б) сунгасан огноо (хэрэв сунгасан бол)	-	
2. Тендерийг нээх огноо, цаг		
(а) анхны огноо, цаг	2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 11 цаг 10 минут	
(б) сунгасан огноо (хэрэв сунгасан бол)	-	
3. Ирээдүйн тендерийн тоо	1	
4. Тендер хүчинтэй байх хугацаа (хоногоор)	Тендер нээснээс хойш 30 хоног	
(а) анхны тогтоосон хугацаа	2023 оны 10 дугаар сарын 22-ны өдөр	
(б) сунгасан хугацаа (хэрэв сунгасан бол)	-	
(в) сунгалтыг үнэлгээний хорооноос Баталсан огноо (шаардлагатай бол)	-	

ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ

Гэрээний нэр, дугаар: "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер.
 Багц № 1: Өндөр идэвхит шийгээний хроматографик багана

№	Тендерт оролцогч	Төрийн бүхий эсэх	Гарын хэрэгжүүлэх чадвартай эсэх	Тендерийн иж бүрдэл	Гарын үсэг зурах итгэмжлэл	Тендерийн баталгаа	Ажлын /барааны/ тоо хэмжээ бүрэн эсэх	Баримт бичгийн үндсэн шаардлагыг хангасан эсэх	Шаардлагад нийцсэн тендер
1.	"Медиконт" ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:

 О.МӨНХСӨӨЛ

ГИШҮҮД:  Ш.АРИУНЗАЯА

 Г.ЦЭРМАА

 А.ДЭМБЭРЭЛ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН
 БИЧИГ:

 Л.МӨНХБАЯР

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ САНАЛ

Багц № 2: Хэрэгжлийн материал (шил сав)

1	Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогч (гэрээ байгуулах эрх олгох санал болгож буй).		
	1.1. Нэр	"Медиконт" ХХК	
	1.2. Хаяг	Улаанбаатар хот, БГД, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-46, Цэцүүх оффис үйлчилгээний төв, Утас: 70179577	
2	Хэрэгжлийн тендер нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжсан бол жинхэнэ гүйцэтгэлчид:	-	
	2.1 Нэр	-	
	2.2 Хаяг	-	
3	Түнийс орон, гишүүн бүрийн нэр, улс, болон гэрээний гүйцэтгэлийг хариуцах зүвийг жагсаах.	-	
		-	
		-	
4	Барсан материалын гарал үүслийн улс	-	
5	Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-с доошгүй хоногийн дараа гэрээ байгуулна.	Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-с доошгүй хоногийн дараа гэрээ байгуулна.	
6	Барсан материал (хүргэж суурилуулах бүх үйлчилгээ) дуусгах тооцоолсон хугацаа		
7	Тендерийн зарлагдсан үнэ (тендерийн нээхэд зарлагдсан)	Төгрөг	Дүн эсхүл хувь /төгрөг/
			37,950,000.00
8	Алдсарт зарцуулсан		-
9	Үнийн өөрчлөлт		-
10	Бусад зарцуулга		-
11	Гэрээ байгуулах санал болгосон үнэ		37,950,000.00

МЕДИКОНТ ХХК ИЙН КОМПАНИЙ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Медиконт ХХК нь гадаад, дотоод худалдааны чиглэлээр 2010 онд байгуулагдсан бөгөөд 2019 оноос үйл ажиллагаагаа өргөжүүлэн, эрүүл мэндийн салбарт дэвшилтэт технологиор бүтээгдсэн эмнэлгийн багаж хэрэгсэл, протез, урвалж оношлуур, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, дэлхийн стандартад нийцүүлсэн тоног төхөөрөмжийн тохируулга, суурилуулалт, засвар үйлчилгээ үзүүлэхийг эрхэм зорилго тавин ажиллаж байгаа бөгөөд эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрөлтэйгөөр ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- ✓ Эмнэлгийн багаж хэрэгсэл ханган нийлүүлэлт
- ✓ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдаа ханган нийлүүлэлт
- ✓ Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тохируулга, суурилуулалт, засвар үйлчилгээ, сургалт зохион байгуулах
- ✓ Эмнэлгийн протез, урвалж оношлуур ханган нийлүүлэх

Бид харилцагч, үйлчлүүлэгчиддээ зөвлөгөө, заавар өгч ажиллахын тулд эмч төлөөлөгч, эм зүйч, хүнсний технологич, тоног төхөөрөмжийн инженер зэрэг уг салбарт мэргэшсэн нарийн мэргэжлийн боловсон хүчнээр багаа бүрдүүлэн ажиллаж байна.

Манай байгууллага нь АНУ, Япон, БНСУ, БНЭУ, ХБНГУ, БНХАУ ын олон улсын чанарын шаардлага хангасан эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн нэг удаагийн хэрэгслийг зах зээлд нийлүүлэн ажиллаж байгаа ба “Abbott”, “Rebstock”, “Biotronik”, “Jeil”, “Top Glove”, “Arista”, “Maxter”, “Orich”, “Desu”, “B Braun”, “Soering” зэрэг компаниудтай дистрибьютерийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Одоогоор манай худалдаанааы төв нь 30 гаруй нэр төрлийн тоног төхөөрөмж, 300 нэрийн эмнэлгийн хэрэгсэл худалдаалж, мөн захиалгаар нийлүүлэн ажиллаж байна.

Бид 2020 оны 08 дугар сараас эхлэн Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг 3-р шатлалын томоохон эмнэлгүүд, мөн 2-р шатлалын 20 гаруй эмнэлэг, 10 гаруй аймгуудын ЭМГ, БОЭТ, Нэгдсэн эмнэлгүүд, 20 гаруй

хувийн эмнэлэг, 10 гаруй аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Манай байгууллага нь 890 м.кв бүхий GDP стандартад нийцсэн агуулахын байртай бөгөөд температурын заагтай бүтээгдэхүүнийг тээвэрлэх зориулалтын тоноглогдсон тээврийн хэрэгсэлтэй болно.

Манай байгууллагад Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж ирсэн мэргэжлийн эмч, эм зүйч, химич, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нарийн мэдлэг, туршлагатай ур чадвартай инженерүүд зэрэг мэргэжлийн, туршлагатай баг хамт олон эмнэлгийн хэрэгсэл, протез, урвалж оношлуур, тоног төхөөрөмжийг саадгүй нийлүүлэхийг зорин ажиллаж байна.

Мөн хэрэглэгч, захиалагч нартай аль болох ойр, хурдан шуурхай ажиллахын тулд ERP системийг үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.

КОМПАНИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Аж ахуйн нэгж, байгууллагын байршил:
Улаанбаатар хот, БЗД, 2-р хороо, Цэргийн хотхон, 62 тоот
- Утас: 976-78008899 Факс: 976-78009988
- Харьяалал: *ЧД-ийн татварын хэлтэс*
- Харилцагч банк: *ХХБ. Төгрөгийн 461033317, Ам.долларын 461033318*
- Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны зориулалт, үйлчилгээний чиглэл:
 - Гадаад худалдаа
 - Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллага
- Аж ахуйн нэгж байгууллагын эрх баригч эзний овог нэр: *Захирал Д.Баяржаргал*

Огноо: 2023 оны 09 дугаар сар 22

**Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар Засгийн газрын
хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар**

Манай “Медиконт” ХХК нь танай байгууллагаас зарласан Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ЭЭХХЗГ/202302002 дугаартай тендер шалгаруулалтад:

БАГЦ № БАГЦЫН НИЙТ ҮНЭ Багц 1 37,950,000 төгрөг

Бид 37,950,000 /Гучин долоон сая есөн зуун тавин мянган/ төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендрийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтанд оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхгүй.
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийн нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

Тендер оролцогчийн нэр: Медиконт ХХК

Гарын үсэг /амга

Албан тушаал, нэр Гүйцэтгэх захирал Д.Баяржаргал

Хаяг: БЗД-2-р хороо, Цэргийн хотхон, 62 тоот



Medicont

(Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног
техөөрөмж ханган нийлүүлэх төв)

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2-р хороо,
Цэргийн хотхон, 62 тоот.
Утас: 976-78009988, 78008899 Факс: 976-78008899,
E-mail: sales@medicont.mn Web site: medicont.mn

Маягт 2

БАРААНЫ ҮНИЙН ЗАДАРГАА


Багц 1 Өндөр идэвхит шингэний хроматографийн багана

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
№	Барааны нэр	Гарал үүслийн улс	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4*6)	Барааг эсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тгээрэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх
1	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:15cm Дотоод диаметр /I.D/:4,6mm Eclipse Plus C18 4.6x150mm, 5um	АНУ	1	Ширхэг	3,000,000	3,000,000	-	300,000	3,300,000	Үгүй
2	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm Eclipse Plus C18 4.6x50mm, 5um	АНУ	1	Ширхэг	2,500,000	2,500,000	-	250,000	2,750,000	Үгүй
3	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 4um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm Pursuit 3 C18, 4.6x50mm, 3um	АНУ	1	Ширхэг	2,000,000	2,000,000	-	200,000	2,200,000	Үгүй
4	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4mm Pursuit 5 C18 50 X 4.6mm, 5um	АНУ	1	Ширхэг	2,000,000	2,000,000	-	200,000	2,200,000	Үгүй
5	C8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:25cm Дотоод диаметр /I.D/:4,6mm Eclipse Plus C8, 4.6x250mm, 5um	АНУ	1	Ширхэг	3,500,000	3,500,000	-	350,000	3,850,000	Үгүй
6	C8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:15cm Дотоод диаметр /I.D/:4,6mm C8 Analytical HPLC Column 4.6 X 150	АНУ	1	Ширхэг	3,000,000	3,000,000	-	300,000	3,300,000	Үгүй

7	C8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm Eclipse Plus C8, 4.6x50mm, 5um RP-18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm	АНУ	1	Ширхэг	2,500,000	2,500,000	250,000	2,750,000	Үгүй
8	Дотоод диаметр /I.D/:4,6mm Symmetry Shield RP18 Column, 100A, 5um, 4.6 mm X 50 mm RP-18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:1.5cm	АНУ	1	Ширхэг	4,500,000	4,500,000	450,000	4,950,000	Үгүй
9	Дотоод диаметр /I.D/:4,6mm Symmetry Shield RP18 Column, 100A, 5um, 4.6 mm X 150 mm RP-8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm	АНУ	1	Ширхэг	4,500,000	4,500,000	450,000	4,950,000	Үгүй
10	Дотоод диаметр /I.D/:4,6mm Symmetry Shield RP8 Column, 100A, 5um, 4.6 mm X 50 mm RP-8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:1.5cm	АНУ	1	Ширхэг	3,500,000	3,500,000	350,000	3,850,000	Үгүй
11	Дотоод диаметр /I.D/:4,6mm XTerra Shield RP8 Column,12, 5um, 4.6 mm X 150 mm	АНУ	1	Ширхэг	3,500,000	3,500,000	350,000	3,850,000	Үгүй
Тендерийн нийт үнэ								37,950,000	

Тендерт оролцогчийн нэр: "Медиконт" ХХК

Гарын үсэг:



Medicont

Эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног
техөөрөмж ханган нийлүүлэх төв

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Цэргийн хотхон, 62
тоот.
Утас: 976-78009988, 78008899 Факс: 976-78008899,
E-mail: sales@medicont.mn Web site: medicont.mn


БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Багц 1 Өндөр идэвхит шингэний хроматографийн багана

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, гун	ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Бараа нийлүүлэх хугацаа	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа
1	Өндөр идэвхит шингэний хроматографийн багана	3	4	5	6	60 хоног	7
1		11	Ширхэг	Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар		60 хоног	

Тендерт оролцогчийн нэр: "Медиконт" ХХК

Гарын үсэг:



Захиалагч: Төрийн худалдан авах ажиллагааны газар

2023.09.20

Багц/Дугаар: Багц 1

Багцын нэр: Өндөр идэвхит шингэний хроматографийн багана

Барааны нэр:

Д/д	Захиалагчийн техникийн тодорхойлолт	Медиконт ХХК аас санал болгож буй техник тодорхойлолт	Тайлбар
1	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:15cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Eclipse Plus C18 4.6x150mm, 5um	
2	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Eclipse Plus C18 4.6x50mm, 5um	
3	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 4um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Pursuit 3 C18, 4.6x50mm, 3um	1.Уг үзүүлэлтийг үнэн зөв болохыг нотлох баримтын линк:
4	C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4mm	Pursuit 5 C18 50 X 4.6mm, 5um	https://www.agilent.com/store/en_US/Prod-959993-902/959993-902
5	C8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:25cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Eclipse Plus C8, 4.6x250mm, 5um	
6	C8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:15cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	C8 Analytical HPLC Column 4.6 X 150	
7	C8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Eclipse Plus C8, 4.6x50mm, 5um	
8	RP-18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Symmetry Shield RP18 Column, 100A, 5um, 4.6 mm X 50 mm	https://www.waters.com/nextgen/mx/es/shop/columns/186000218-symmetry-shield-rp18-column-100a-5--m-46-mm-x-50-mm-1-pk.html
9	RP-18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:15cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Symmetry Shield RP18 Column, 100A, 5um, 4.6 mm X 150 mm	
10	RP-8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:5cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	Symmetry Shield RP8 Column, 100A, 5um, 4.6 mm X 50 mm	
11	RP-8 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:15cm Дотоод диаметр /I.D/:4,6mm	XTerra Shield RP8 Column,125, 5um, 4.6 mm X 150 mm	

Үндсэн баримт бичиг: Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, Үйлдвэрлэгчийн хүчин чадлын мэдээлэл, Бүтээгдэхүүн борлуулах гэрээ, Үйлдвэрлэгчийн каталоги, Импортын лиценз тендерийн материалд хавсаргав.

Үйлдвэрлэгчийн зураг:

C18 Жижиг хэсгийн хэмжээ /particle size/: 5um Урт/L/:15cm Дотоод диаметр /I.D/:4,6mm

Eclipse Plus C18 4.6x150mm, 5um



20

C18 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:5cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

Eclipse Plus C18
4.6x50mm, 5um



C18 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 4um Урт/L/:5cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

Pursuit 3 C18,
4.6x50mm, 3um




C18 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:5cm
Дотоод диаметр /I.D/:4mm

Pursuit 5 C18
4.6x50mm, 5um




C8 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:25cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

Eclipse Plus C8,
4.6x250mm, 5um



C8 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:15cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

C8 Analytical
HPLC Column
4.6x150mm



C8 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:5cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

Eclipse Plus C8,
4.6x50mm, 5um



RP-18 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:5cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

Symmetry Shield
RP18 Column,
100A, 5um, 4.6
mm X 50 mm



RP-18 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:15cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

Symmetry Shield
RP18 Column,
100A, 5um, 4.6
mm X 150 mm



RP-8 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:5cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

Symmetry Shield
RP8 Column,
100A, 5um, 4.6
mm X 50 mm



RP-8 Жижиг хэсгийн хэмжээ
/particle size/: 5um Урт/L/:15cm
Дотоод диаметр /I.D/:4,6mm

XTerra Shield
RP8 Column, 125
, 5um, 4.6 mm X
150 mm



Тендерт оролцогчийн нэр: Медиконт ХХК

Гарын үсэг



22

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ХУВААРЬ

Дугаар	Тоног төхөөрөмж	Ерөнхий ашиглалтын сургалт	Инженер, техникчид	Эмгэг судлалын техникч нарт
1	Өндөр идэвхит шингэний хроматографийн баганаг	Сургалтын агуулга: Тоног төхөөрөмж дээрх аюулгүй ажиллагааны практик дадлага олгох, төхөөрөмжийг зөв утсрах ашиглах.	Сургалтын агуулга: Тоног суурилуулалт, ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ, практик дадлага өгөх. Тохиолдож болох энгийн алдааг таньж мэдэх, утсаар заавар зөвлөгөө авах.	Сургалтын агуулга: Тоног төхөөрөмжүүд ашиглалт, аюулгүй ажиллагааны практик дадлага олгох Багажуудтай зөв аргаар харьцах, цэвэрлэх, ариутгах, хадгалах

Тоног төхөөрөмжийн суурилуулалт болон сургалтыг манай байгууллагын инженерүүд хийнэ.



Б.Цэрэнтогтох

Баталсан: Ахлах инженер

